

Шинэ байр

Дээрх зурагт шинэ байрны зургийг үзүүлэв. Хамгийн том талбайтай өрөө гаргахын тулд нурааж болох ханануудын тоог олох програм бич.

Байр нь $m \times n$ үүрнээс тогтоно ($m \leq 50, t \leq 50$). Үүр болгон 0-ээс 4 ширхэг ханатай байж болно.

Оролт

Эхний хоёр мөрөнд хойноос урд чиглэлд байх үүрийн тоо болон баруунаас зүүн чиглэлд байх үүрийн тоо өгөгдөнө.

Дараагийн мөрүүдэд үүр болгоныг илэрхийлэх p тоонууд байрлана ($0 \leq p \leq 15$). Энэ тоо нь дараах тоонуудын нийлбэр юм: 1 (хэрэв уг үүр баруун талдаа ханатай бол), 2 (хойд), 4 (зүүн), 8 (урд).

Дотоод хана нь хоёр үүрт харъяалагдана. Жишээ нь (1, 1) үүрний урд хана нь (2, 1) үүрний хойд хана болно. Байр нь дор хаяж хоёр өрөөтэй байна.

Гаралт

Ганц мөрөнд бодлогын нөхцөл хангах ханануудын тоог гаргана.

Жишээ оролт

4

7

11 6 11 6 3 10 6

7 9 6 13 5 15 5

1 10 12 7 13 7 5

13 11 10 8 10 12 13

Жишээ гаралт

4

Тайлбар: (4, 1) өрөөний зүүн, (3, 3) өрөөний зүүн, (3, 2) өрөөний урд, (3, 3) өрөөний урд гэсэн дөрвөн хананы аль нэгийг нураахад 16-н үүрнээс тогтох хамгийн том өрөө үүснэ.